БАТЛАВ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАТ-ЭРДЭНЭ

САЙНШАНД СУМЫН 3 БАГ "НОМИН ХУДАЛДААНЫ ТӨВ"-ИЙН ХОЙД ТАЛААР БАРИХ АВТО ЗАМЫН АЖЛЫН ДААЛГАВАР /1.21 км/

2026 оны 01-р сарын 09-ны өдөр *Сайншанд сум*

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Сайншанд сумын 3 баг, номин худалдааны төвийн хойд талаар барих авто замын ажлыг гүйцэтгэнэ.

А.Ажил гүйцэтгэх хугацааны график төлөвлөгөө (хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүч, машин механизмын тоо) тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи ажлын аргачлалыг гаргаж ирүүлнэ.

Б.Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм ЗЗБНбД 81-013-2019, Авто замын барилгын ажлын төсвийн жишиг норм ЗЗБНбД 83-25-2023, Төмөрбетон гүүр, хоолойн барилгын төсвийн жишиг норм ЗЗБНбД 83-28-2023, Авто замын засвар арчлалтын төсвийн жишиг норм ЗЗБНбД 83-26-2023 баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

В.Авто замын тэмдэг, тэмдэглэл MNS4596-2007, хурд сааруулагч техникийн ерөнхий шаардлага, хэрэглэх дүрэм MNS5968-2009, авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын арга технологи БНбД 13-03-00 баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

Г.Барилгын угсралтын ажилд бетон зуурмагийг цутгах ажилд "Цутгамал төмөр бетон бүтээцийн ажил гүйцэтгэх заавар" БД 52-102-04 болон "Цутгамал бетон, төмөр бетоны бүтээц" БНбД 52-02-05-ын дагуу бетон зуурмагийн конусан суултыг заавал тодорхойлж, цутгасан хийц бүтээц бүрийн бетон зуурмагаас дээж авч, бетоны шахалтын бат бэхийг итгэмжлэгдсэн лабораториор тодорхойлуулан цутгамал бүтээцийн бат бэхийг хангуулж байх, цутгалтын дараах бетоны арчилгааг шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

Авто замын барилгын ажил:

-Авто замын барилга угсралтын ажлыг ажлын тоо хэмжээний дагуу чанартай хийж гүйцэтгэнэ.

-Ажлыг гүйцэтгэхдээ талбайн хэмжилт, гадаслагаа зэргийг зурагт заагдсан кординат трассын дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

-Авто замын барилга угсралтын ажлыг авто зам барих ажлын технологийн дараалын дагуу гүйцэтгэнэ.

Тендерийн материалд тавигдах шаардлага:

1.Төсвийн тооцоог Зам, Тээврийн Хөгжлийн сайдын 2023 оны 05-р сарын 05-ны өдрийн А/141-р тушаалаар батлагдсан төсвийн норм, төсөв зохиох компьютерын Road Estimator программ ашиглан гүйцэтгэх.

2.Төсөв зохиоход Зам барилгын ажлын товчоог Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 01-р сарын 28-ны өдрийн А/20-р тушаалын дагуу тооцох.

3. Ажилчдын тарифт цалинг Зам, Тээврийн сайдын 2024 оны 11-р сарын 18-ны өдрийн А/243-р тушаалын дагуу, нэмэгдэл цалинг мөн дээрх нормын дагуу ажилчдын үндсэн цалин, тээврийн жолоочийн цалин, машин механизмын операторчдын цалин, нүүлгэн шилжүүлэх ажлын цалингийн нийлбэрээс 15.1%-иар бодож төсөвт тусгав.

ИТА-н цалинг замын барилгын ажилчдын цалин, Тээврийн жолоочийн цалин, Машин механизмын операторчидын цалингийн нийлбэр дүнгээс 17 хувиар тооцох.

4.Монгол Улсын нийгмийн даатгалын тухай хуулийн 15.1 зүйлд заасны дагуу ажил олгогч /компани/-ийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг зам барилгын ажилчдын цалин, нэмэгдэл цалин, талбайн инженер техникийн ажилтнуудын цалингийн нийлбэр буюу нийт цалингийн сангийн 11.7%-иар, Засгийн газрын 2008 оны 142-р тогтоолын дагуу "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал"-ын шимтгэлийн хувь хэмжээг 2.8%-иар нийт 14.5%-иар тооцож төсвийн тооцох.

5.ЗТАЖ-ын сайдын 2007 оны 11-р сарын 20-ны өдрийн 187-р тушаалын дагуу удирдлагын зардлыг нийт цалингийн сангийн 63.5%-иар, ашгийн хэмжээг цалингийн сангийн 71.8%-иар бодож тооцох.

6. Автомашинаар ачаа тээвэрлэх зардлыг ЗТХЯ-ны сайдын 2019 оны 07-р сарын 31 өдрийн 256-р тушаалын 1 дугаар хавсралт, Машин механизмын ажлын нэгж маш/цаг-ийн зардлыг Зам, Тээврийн сайдын 2024 оны 11-р сарын 18-ны өдрийн А/243-р тушаалаар батлагдсан жишиг тариф, "Замын машин механизмын ашиглалтын цагийн жишиг үнэ"-ийн дагуу тооцох.

7.Магадалшгүй ажлын зардлыг барилга угсралтын дүнгээс 2%, Нэмэгдсэн өртгийн албан татварыг "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай" МУ-ын хуулийн 11-р зүйлийн 11.1-р заалтын дагуу барилга угсралтын ажлын зардлын дүнгээс 10%-иар тооцож төсөвт тусгах.

8.ХАБЭА-н үйл ажиллагааны зардлыг шууд зардлын дүнгээс 2.5%-иар тооцож төсөвт тусгана. Энэ зардал нь "Авто замын салбарын үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын иж бүрэн дүрэм"-ийн дагуу замын барилгын ажлын туршид хийгдэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны зардал юм.

9.Материалын үнийг бодохдоо төсөвт өртгийн товчоон дээр НӨАТ бодогдсон учраас 10%-ыг хасаж зах зээлийн жишиг үнийн дагуу тооцох.

10.Засгийн газрын 2023 оны 12-р сарын 20-ны өдрийн 463-р тогтоолоор "Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам"-д орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу карьерийн материалыг 1 төгрөгөөр тооцох.

11.Зураг төсвийн үнэ 8,000,000 төгрөгийг төсөвт тусгах.

12.Авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажлын мэргэшсэн инженертэй байх.

13.Ажлын талбайтай танилцсан тухай тэмдэглэл, фото зургийн хамт баталгаажуулж ирүүлэх.

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

ТҮР БАРИЛГА БА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ			
Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
25-01-03	Ажилтнуудын зөөврийн сууц байрлуулах	1 ш	1.0
25-01-16	Галын пост түр байрлуулах	1 пост	1.0
25-01-24	Зөөврийн био 00 (нойл) байрлуулах	1 сар	1.6
ЗАМЫН ЧИГ СЭРГЭЭХ, ГАДАСЛАХ			
Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
25-02-02	Замын чиг сэргээх (GPS)	1 км	1.21
ЗАМЫН ДАЛАН, УХМАЛЫН АЖИЛ			
Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
25-07-12	Тохиромжгүй материал ухаж ачиж, зайлуулах (экскаватороор)	1 м3	5,540.9
25-04-04	Далангийн ул хөрс тэгшлэх, нягтруулах	1 м2	1,569.8
25-07-05	Шороон ордоос зөөврөөр далан байгуулах	1 м3	2,053.5
25-07-08	Хөлдөлтөөс хамгаалах үе	1 м3	3,732.0
ЗАМЫН СУУРИЙН АЖИЛ			
Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
25-08-01	Суурийн доод үе байгуулах	1 м3	2,929.7
25-08-04	Буталсан чулуун хольцоор суурь байгуулах (автогрейдерээр)	1 м3	1,646.4
ЗАМЫН ХУЧИЛТЫН АЖИЛ			
Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
25-10-01	Шингэн цацлага хийх (Prime coat)	1 м2	8,790.3
25-10-04	Халуун асфальтбетон хольцоор суурь үе байгуулах	1 м3	351.6
25-10-02	Шингэн түрхлэг хийх (Tack coat)	1 м2	8,790.3
25-10-05	Халуун асфальтбетон хольцоор өнгө үе байгуулах	1 м3	263.7
ЗАМЫН ХАШЛАГА БАЙРЛУУЛАХ			
Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
25-09-02	Замын хашлага байрлуулах (1.0 x 0.3 x 0.18 м)	1 м	2,435.0
ЯВГАН ЗАМЫН АЖИЛ			
Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
20-07-02	Суурийн ухмал ухах	1 м3	339.6
25-13-01	Явган замын суурь зохист найрлага бүхий элс хайрган хольцоор байгуулах	1 м3	849.0
25-13-05	Явган замын хашлага байрлуулах	1 м	2483.7
25-13-09	Явган хүн ба унадаг дугуйн замын суурь буталсан чулуун хольцоор байгуулах	1 м2	419.7
25-10-17	Гараар цацлага хийх	1 м2	3,396.0
25-13-06	Явган хүний замын хучлага халуун асфальтбетон хольцоор гараар байгуулах	1 м3	135.8
25-14-03	Замын тэмдэглэгээг зориулалтын машинаар термопластик будгаар хийх	1 м2	441.5
ЗАМЫН ХАЙРГАН ХӨВӨӨ БАЙГУУЛАХ			
Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
25-11-01	Хайрган хөвөө гараар байгуулах	1 м3	508.2
ЗАМЫН УС ЗАЙЛУУЛАХ ЭНГИЙН БАЙГУУЛАМЖИЙН АЖИЛ			
Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
28-16-01	Суурийн ухмал ухах	1 м3	38.0
25-22-12	Замын гадаргуугийн ус зайлуулах сувгийн тэвш байрлуулах (УЗС-1-1) 500x300x180	1 м	128.0
28-16-10	Ул бетон болон бэхэлгээний бетон хийх	1 м3	13.2

ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ АЖИЛ			
Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
25-14-03	Замын тэмдэглэгээг зориулалтын машинаар термопластик будгаар хийх	1 м2	338.3
ЗАМЫН ТОНОГЛОЛЫН АЖИЛ			
Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
25-15-01	Замын тэмдэг суурилуулах	1 ш	33.0
25-09-02	Налуу гарц хийх	1 м	39.0
25-14-04	Халтиргаанаас хамгаалах өнгөт тэмдэглэгээ хийх	1 м2	500.0
БУСАД АЖИЛ			
Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
25-22-07	Хурд сааруулагч байгуулах	1 м3	18.0
25-22-01	Цэвэр усны шугмын худгийн таг өндөрлөх	1 ш	6.0
25-22-01	Бохир усны шугмын худгийн таг өндөрлөх	1 ш	12.0
28-17-05	Бохир усны шугам нөөцлөх сав, d200	1м	320.0
ТӨМӨРБЕТОН ДӨРВӨЛЖИН ХООЛОЙН БАРИЛГА - 1Х1 М			
Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
28-16-01	Хоолойн суурийн ухмал	1 м3	33.6
28-16-02	Хоолойн ул суурь нягтруулах	1 м2	84.0
28-16-03	Хоолойн суурийг зохистой ширхэглэл бүхий элс хайргаар байгуулах	1 м3	7.2
28-25-01	Төмөрбетон суурь байгуулах	1 м3	4.56
28-25-02	Хоолойн хэсэглэл суурин дээр угсрах	1 м	13.0
28-17-04	Хоолойн толгой, далбааны хэсэглэл цутгах	1 м3	7.36
28-16-12	Түрхмэл ус тусгаарлагч хийх	1 м2	68.4
28-16-13	Далангийн хажуу налуугийн элс цементэн зуурмагтай чулуун бэхэлгээ хийх	1 м2	9.36
28-16-14	Хоолойн орох, гарах хэсгийн чулуун бэхэлгээ хийх	1 м3	5.6
28-17-01	Орох гарах амсрын шал бетон цутгах	1 м3	5.6
28-02-05	Арматурын хэлхээс бэлтгэх	1 тн	0.96
АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙГ УЛСЫН АШИГЛАЛТАД ОРУУЛАХ			
Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
25-20-01	Авто зам, замын байгууламжийн гүйцэтгэлийн зураг боловсруулах	1 км	1.21
25-20-02	Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах	1 км	1.21
25-19-02	Зам ашиглатад өгөх үеийн хог цэвэрлэх	1 км	1.21

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:
БОНХОБТХ-ИЙН ДАРГА Ц.МӨНХ-ЭРДЭНЭ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:
САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
ХОТЫН ЗАХИРАГЧ Ч.ТҮВШИНТӨР